



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/27

Чингис хот

Халаалт тооцох эзлэхүүнд хэмжилт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц сангийн зарцуулалт, зориулалтын нийтлэг журам", Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолоор баталсан "Аж ахуйн харилцааны дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум, тосгодод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн өмчит байгууллагуудын халаалт тооцох эзлэхүүнийг барилга, объект тус бүр дээр биет хэмжилт хийж тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиглэлийг 1 дүгээр хавсралтаар, шатахууны зардалд шаардагдах 1010620 /нэг сая арван мянга зургаан зуун хорин/ төгрөгийн хөрөнгө зарцуулалтын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажлын хэсгийн гишүүдийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010102

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиглэл

№	Ажлын хэсгийн гишүүд	Ажиллах сум, тосгон	Нийт км
1 дүгээр ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Н.Хүрлээ /Цэргийн штабын дарга/ Гишүүд: Ш.Ариунболор /ГХБХБГ-ын мэрэгжилтэн/ тухайн сумын төрийн болон төрийн өмчит байгууллагын удирдлага, дулаан хангагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан	Баянмөнх, Галшар, Бор- Өндөр, Дархан, Баянхутаг	470
2 дугаар ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Б. Дарханбаатар /Хууль, эрх зүйн хэлтэсийн дарга/ Гишүүд: Б.Содбилэг /ГХБХБГ-ын мэрэгжилтэн/, тухайн сумын төрийн болон төрийн өмчит байгууллагын удирдлага, дулаан хангагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан	Өмнөдэлгэр, Гурванбаян тосгон, Батширээт, Биндэр, Баян-Адарга	575
3 дугаар ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: С.Нямдаваа /Санхүү, төрийн сангийн хэлтэсийн дарга/ Гишүүд: Э.Элбэг-Эрдэнэ /ГХБХБГ-ын мэрэгжилтэн/ тухайн сумын төрийн болон төрийн өмчит байгууллагын удирдлага, дулаан хангагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан	Мөрөн, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Хэрлэнбаян-Улаан тосгон, Цэнхэрмандал	480
4 дүгээр ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Г.Лхагвахатан /Нийгмийн бодлогын хэлтэсийн дарга/ Гишүүд: Д.Эрхэмбаяр /Эрчим хүчний зохицуулах хорооны орон тооны гишүүн/ тухайн сумын төрийн болон төрийн өмчит байгууллагын удирдлага, дулаан хангагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан	Бэрх тосгон, Батноров, Дадал, Норовлин, Баян- Овоо	625

аг даргын 2021 оны
н. 19 өдрийн А/27...
оёрдугаар хавсралт

Нийт км	Нийт дүн
------------	----------

Зардлын тооцоо

№	Зардлын зүйл	Төрөл	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Тоо хэмжээ /литр/	100 км норм /литр/	Нийт км	Нийт дүн
1	Шатахуун	A92	1530	144	20	470	220320
2	Шатахуун	A92	1530	165	20	575	252450
3	Шатахуун	түлш	1850	146	20	480	270100
4	Шатахуун	A92	1530	175	20	625	267750
			Бүгд				1010620